

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	2
2	Аудитын тайлан.....	4
2.1.	Оршил.....	4
2.2.	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3.	Аудитын мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4.	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5.	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6.	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7.	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8.	Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9.	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10.	Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11.	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12.	Шилэн дансны мэдээлэл	8
2.13.	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	8
2.14.	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	13
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	14
5	Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн хөгжлийн банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР ТӨСӨЛ-1
НЭГЖИЙН ЗОХИЦУУЛАГЧ
А.ХҮРЭЛБАТ ТАНАА

2020.03.31 № 06/978
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2. Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй дүгнэлт

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтөлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төслийн зохицуулагч А.Хүрэлбат Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл хөтөлөлтөд нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төслийн нэгжийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Ди Эй Би Жи Аудит” ХХК-ийн аудитор Э.Цэрэннадмид хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 398 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Монгол Улсын Засгийн газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2015 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл 1-ийг хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан. Төслийг хэрэгжүүлэхэд Дэлхийн байгаль орчны сангийн буцалтгүй тусламжаар 1.5 сая, Азийн хөгжлийн банкны энгийн эх үүсвэрийн зээлээр 29.7 сая, хөнгөлөлттэй зээлээр 30.2 сая, Монгол Улсын Засгийн газар 17 сая ам долларыг тус тус санхүүжүүлэхээр тохиржээ.

Өнөөгийн цэвэр үнэ цэнээр илэрхийлсэн Улсын нийт өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх жинг 40 хувиас хэтрүүлэхгүй байх тухай Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон Засгийн газар өөрчлөгдсөнтэй холбоотой 2014 оны 03 дугаар сарын 21, 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрүүдэд Санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн хугацааг 2 удаа 24 сараар сунгасан байна. Нийслэлийн Засаг даргын тамгын газар болон Сангийн яамнаас төслийн зээлийг хаах хугацааг 5 жилээр сунгах санал гаргасан боловч Азийн хөгжлийн банкны зээлийн гэрээ хаах хугацааг 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүртэл сунгасан байна.

Төслийн зорилго:

Тусгай замын автобусны үйлчилгээ нэвтрүүлэх, хувийн тээврийн хэрэгслийн хэрэглээг бууруулах замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийг тогтвортойгоор хөгжүүлэхэд оршино.

Нийслэлийн засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 01/482 тоот албан бичгээр Сангийн сайдад төслийн хэрэгжүүлэх хугацааг сунгах тухай хүсэлт илгээснийг холбогдох байгууллагууд хэлэлцэж, төслийн хугацааг сунгахгүй хаахаар шийдвэрлэсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгж нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байхгүй. Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагнал нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгж нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Инфосистем” програм хангамж ашигладаг байна.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, эрсдлийн түвшинг “БАГА” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 949,981.8 мянган төгрөгөөс тооцон 18,999.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 25,645.1 мянган төгрөгөөр тооцсон 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтой холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 267,263.1 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, богино хугацаат өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,553,851.7	6,321,720.3	(232,131.40)
Авлага	-	2,639.2	2,639.2
Бараа материал	1,184.1	1,184.1	-
Үндсэн хөрөнгө	207,332.7	171,274.8	(36,057.9)
Биет бус хөрөнгө	4,996.2	3,283.2	(1,713.0)
Нийт хөрөнгө	6,767,364.7	6,500,101.6	(267,263.1)
Богино хугацаат өр төлбөр	34,979.7	2,592.5	(32,387.2)
Хуримтлагдсан үр дүн	6,732,385.0	6,497,509.1	(234,875.9)
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,767,364.7	6,500,101.6	(267,263.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант онд зээл, тусламжийн санхүүжилтын орлого хүлээн аваагүйтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл өссөн нь ажиллагсдын цалин хөлсний зардлаас тооцон төлөх нийгмийн даатгал, хувь хүний орлогын албан татварын суутгалыг илүү төлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаар хуримтлагдсан элэгдлийн дүн өссөнөөс шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл буурсан нь өмнөх оны ажиллагчидтай холбоотой өглөгийг төлж барагдуулснаас шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга 5,672.4 мянган төгрөгийн бичилт нь өмнөх оны ажиллагчидтай холбоотой зардлуудын төлбөр тооцоог тайлант онд зарцуулсантай холбоотой байна.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нь 2019 онд 862,213.4 мянган төгрөгийн зээлийн санхүүжилтийн төсөв батлагдсан. Зээлийн гэрээний хугацаа 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр дуусч байгаа учир нэмж санхүүжилт татахгүй урьдчилгаа санхүүжилтийн үлдэгдлээр зардлыг санхүүжүүлсэн байна.

Зээлийн гэрээний дагуу тайлант оны хуваарийн дагуу зээлийн хүү, амлалтын шимтгэлийн зардалд 203,608.9 мянган төгрөгийг АХБ-наас шууд төлбөрөөр санхүүжилт хийсэн байна. Мөн тусгай дансны мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг хаалтын ханшаар тэгшитгэн 208,732.4 мянган төгрөгийг төсвийн гүйцэтгэлийн тайланд тохируулан тайлагнасан байна.

Хүснэгт 2. Орлогын гүйцэтгэл

/мянган төгрөг/				
Санхүүжилт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Зээлийн санхүүжилт-урсгал зардал	862,213.4	-	(862,213.4)	-
Зээлийн санхүүжилт-шууд төлбөр	-	203,550.6	203,550.6	-
Нийт дүн	862,213.4	203,550.6	(658,662.8)	23.6

Тайлант онд хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт 862,213.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Урсгал зардалд 862,213.4 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 516,663.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нийт төсвийн гүйцэтгэл 345,549.7 мянган төгрөгөөр хэмнэгдсэн нь зээлийн гэрээний дагуу төслийн хэрэгжих хугацаа дуусч байгаа тул зөвхөн төслийн нэгжийн үйл ажиллагааны зардлууд гарсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 10 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 9,337.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 5,231.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 4,106.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 4 асуудлаар нийт 5,231.5 мянган төгрөгийн алдааг залруулан тайлагнасан. Үүнд:

- 2019 оны бараа, үйлчилгээний худалдан авалтын НӨАТ-ын чөлөөлөлт 2,080.3 мянган төгрөгийг Засгийн газрын санхүүжилтээр бүртгэж, Санхүүгийн үр дүнгийн тайланд тайлагнаагүй нь Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт 2.7.в-д "Засгийн газрын санхүүжилтэд гадаад зээлийн хөрөнгөөр нийлүүлэгдэж байгаа бараа, материал, сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гааль болон НӨАТ-ын татвараас чөлөөлөгдсөн дүнг оруулна" гэснийг,
- Ам долларын харилцах дансны үлдэгдлийг хаалтын ханшаар хөрвүүлэн тайлагнахдаа валютын ханшийн зөрүүгийн олзыг 1,842.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан

- Сангийн сайдын 2007 оны 326 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 2.14.а-д тайлангийн хугацааны эцэст байгаа гадаад валютын үлдэгдлийг тайлангийн өдрийн Монгол банкны зарласан гадаад валютын ханшаар үнэлэнэ” гэснийг,
3. Цалингаас суутгасан боловч нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд тайлагнаагүй 522.4 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэснийг,
 4. Өмнөх оны ажиллагчидтай холбоотой зардлыг залруулан тайлагнахдаа 786.8 мянган төгрөгөөр зөрүүтэй залруулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсний дагуу залрууллаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад төслийн хэрэгжих хугацааг сунгахгүй 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр дуусган хаах шийдвэрийг гаргасан тул дараагийн аудитаар нийт хэрэгжсэн гэрээний гүйцэтгэлийг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 17 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Төсөл хэрэгжиж эхэлснээс хойш гол худалдан авалтуудын тендер зарлагдсан ч цуцлагдсан, хийгдсэн зөвлөх үйлчилгээний ажлуудын үр дүнг тодорхой үнэлээгүй мөн төслийн удирдах хороог олон удаа сольсон, хийх ажлын төлөвлөгөөг байнга шинэчилж байгаа зэргээс шалтгаалан төслийн үйл ажиллагаа удаашралтай байгаа тул төслийг хугацаанд нь эрчимтэй хэрэгжүүлэх талаар албан шаардлага өгсөн. Төслийн хэрэгжих хугацааг холбогдох байгууллагууд хэлэлцэж, 2020 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөр хаахаар шийдвэр гарсан байна.

Бие даасан хувь зөвлөхүүдийн хийсэн ажлын үнэлгээг тодорхой болгох, үнэлгээний хуудсуудыг бүртгэж байх талаар зөвлөмж өгсөнийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны санхүү, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Зөрчилгүй дүгнэлт:

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нэгжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1 нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Зардлын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 11 дүгээр сарын цалингийн зардлыг 436.4 мянган төгрөгөөр илүү, 9 дүгээр сард 4,542.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.2 "шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэснийг хэрэгжүүлээгүй байна.

3.1.2 Эрсдэл: Ажиллагсдын цалинг нийгмийн даатгалд дутуу тайлагнасан нь тохиолдсон байх, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй байх

3.1.3 Өгсөн зөвлөмж: 9 дүгээр сард дутуу тайлагнасан 2 ажилтны цалингийн зардлыг зөв тодорхойлон нөхөн тайлан гаргаж, баталгаажуулах. Цаашид алдааг давтахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу: НД-ын байгууллагад өмнө нь 2 удаа албан бичгээр нөхөн тайлан өгөх тухай хүсэлт хүргүүлсэн. Хариуцсан байцаагч мэдэж байгаа боловч орхигдуулсан байна. Нийгмийн даатгалын байгууллагаас авсан тодорхойлолтыг хүргүүлээ. Зөрчлийг арилгаж, алдааг давтахгүй ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эхний үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	6,553,851,658.21	6,321,720,321.27
Валютын харилцах данс	6,500,524,604.82	6,216,384,921.94
Төрийн сангийн харилцах данс	53,327,053.39	105,335,399.33
АВЛАГА	-	2,639,203.61
Бусад авлага	-	2,639,203.61
БАРАА МАТЕРИАЛ	1,184,125.00	1,184,125.00
Хангамжийн материал	1,184,125.00	1,184,125.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,555,035,783.21	6,325,543,649.88
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
ҮНДСЭН ХӨРӨНГӨ		
Биет хөрөнгө	207,332,711.71	171,274,719.05
Авто-тээврийн хэрэгсэл	145,000,000.20	145,000,000.20
Хуримтлагдсан элэгдэл	(13,181,818.20)	(27,681,818.22)
Машин, тоног төхөөрөмж	74,792,718.76	74,792,718.76
Хуримтлагдсан элэгдэл	(23,720,039.42)	(42,418,219.06)
Тавилга, аж ахуйн эд хогшил	28,598,130.00	28,598,130.00
Хуримтлагдсан элэгдэл	(4,156,279.63)	(7,016,092.63)
Биет бус хөрөнгө	4,996,250.00	3,283,250.00
Програм хангамж	6,852,000.00	6,852,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,855,750.00)	(3,568,750.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	212,328,961.71	174,557,969.05
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,767,364,744.92	6,500,101,618.93
Богино хугацаат өр төлбөр	-	-
Ажиллагчидтай холбоотой өглөг	15,758,677.89	2,592,532.35
Бусад өглөг	19,221,043.07	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	34,979,720.96	2,592,532.35
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	34,979,720.96	2,592,532.35
ЭЗНИЙ ӨМЧ	-	-
Хуримтлагдсан үр дүн	6,732,385,023.96	6,497,509,086.58
Өмнөх үеийн үр дүн	6,098,769,980.79	6,726,712,611.80
Тайлант үеийн үр дүн	633,615,043.17	(229,203,525.22)
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,732,385,023.96	6,497,509,086.58
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	6,767,364,744.92	6,500,101,618.93

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл	Өмнөх оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,057,951,484.67	281,489,237.27
Татаас санхүүжилтийн орлого	986,340,308.16	205,689,277.70
Зээлийн санхүүжилтийн орлого	794,033,910.00	-
Зээлийн шууд санхүүжилтийн орлого	177,993,998.76	203,608,927.48
МУ-ын Засгийн газрын санхүүжилт	14,312,399.40	2,080,350.22
Бараа ажил үйлчилгээний орлого	71,611,176.51	75,799,959.57
Хүүгийн орлого	71,579,176.51	75,799,959.57
Бусад орлого	32,000.00	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	949,981,815.80	719,425,149.14
УРСГАЛ ЗАРДАЛ	949,981,815.80	719,425,149.14
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	949,981,815.80	719,425,149.14
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	443,457,567.14	271,875,386.00
Цалин	443,457,567.14	271,875,386.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,082,511.49	33,621,112.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	48,082,511.49	33,621,112.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,824,540.00	53,745,420.00
Байрны түрээс	54,824,540.00	53,745,420.00
Хангамж, бараа материалын зардал	9,417,749.61	11,162,904.42
Бичиг хэрэг	1,657,237.35	2,328,242.09
Тээвэр, шатахуун	3,230,000.00	3,625,554.54
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,530,512.26	5,209,107.79
Томилолт, зочны зардал	93,638,024.73	-
Гадаад албан томилолт	93,638,024.73	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	15,425,186.75	21,835,975.40
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	15,274,196.45	21,682,036.26
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,990.30	153,939.14
Бараа үйлчилгээний бусад зардал	285,136,236.08	327,184,351.32
Зөвлөх үйлчилгээний зардал	69,310,459.50	83,724,080.96
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	36,701,196.62	37,770,992.66
Зээлийн хүүгийн зардал	177,993,998.75	203,608,927.48
НӨАТ-ын чөлөөлөлт	1,130,581.21	2,080,350.22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	107,969,668.87	(437,935,911.87)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	608,172,329.83	208,732,386.65
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	608,172,329.83	208,732,386.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	82,526,955.52	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	82,526,955.52	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	633,615,043.18	229,203,525.22)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
(төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,043,639,085.28	279,408,887.05
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,043,639,085.28	279,408,887.05
Татаас санхүүжилтийн орлого	972,027,908.76	203,608,927.48
Зээлийн санхүүжилтийн орлого	972,027,908.76	203,608,927.48
Бараа, ажил үйлчилгээний орлого	71,611,176.52	75,799,959.57
Хүүгийн орлого	71,579,176.52	75,799,959.57
Бусад орлого	32,000.00	-
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	877,170,317.07	720,272,610.64
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	877,170,317.07	720,272,610.64
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	414,449,267.43	280,515,439.38
Цалин	414,449,267.43	280,515,439.38
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,225,333.02	65,679,853.00
Нийгмийн даатгалын шимтгэл	43,225,333.02	65,679,853.00
Тогтмол зардал	54,824,540.00	53,745,420.00
Байрны түрээс	54,824,540.00	53,745,420.00
Хангамж, бараа материалын зардал	9,417,749.61	11,162,914.42
Бичиг хэрэг	1,657,237.35	2,328,242.09
Тээвэр, шатахуун	3,230,000.00	3,625,564.54
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,530,512.26	5,209,107.79
Томилолт, зочны зардал	93,638,024.73	-
Гадаад албан томилолт	93,638,024.73	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	15,425,186.79	21,835,975.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,274,196.45	21,682,036.26
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	150,990.34	153,939.14
Бараа үйлчилгээний бусад зардал	246,190,215.49	287,333,008.44
Зөвлөх үйлчилгээ	68,196,216.73	83,724,080.96
Зээлийн хүү, амлалтын шимтгэлийн төлбөр	177,993,998.76	203,608,927.48
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	166,468,768.21	(440,863,723.59)
Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө худалдан авсан	131,818,182.00	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(131,818,182.00)	-
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	(82,526,955.52)	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	608,172,329.84	208,732,386.65
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	525,645,374.32	208,732,386.65
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	560,295,960.53	(232,131,336.94)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,993,555,697.66	6,553,851,658.21
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,553,851,658.21	6,321,720,321.27

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын хувь оролцоо	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны дүн
2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		6,098,769,980.79	6,098,769,980.79
Тайлант үеийн үр дүн		633,615,043.17	633,615,043.17
2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		6,732,385,023.96	6,732,385,023.96
Өмнөх оны алдааг залруулсан		(5,672,412.16)	(5,672,412.16)
Залруулсан үлдэгдэл		6,726,712,611.80	6,726,712,611.80
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		(229,203,525.86)	(229,203,525.86)
2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл		6,497,509,085.94	6,497,509,085.94

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

ЭДИЙН ЗАСГИЙН АНГИЛАЛ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-			
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	862,213,400.00	516,663,683.16	345,549,716.84	59.9
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	862,213,400.00	516,663,683.16	345,549,716.84	59.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,213,400.00	516,663,683.16	345,549,716.84	59.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	862,213,400.00	516,663,683.16	345,549,716.84	59.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	862,213,400.00	516,663,683.16	345,549,716.84	59.9
Бараа үйлчилгээний бусад зардал	-	-	-	100.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	-	-	-	100.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗАРДАЛ	-	-	-	
Бусад хөрөнгө	-	-	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	862,213,400.00	75,799,959.57	786,413,440.43	8.8
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	-	75,799,959.57	(75,799,959.57)	100.0
Хүүгийн орлого	-	75,799,959.57	(75,799,959.57)	100.0
Бусад орлого	-	-	-	100.0
Эх үүсвэрээс санхүүжих	862,213,400.00	-	862,213,400.00	
Зээлийн санхүүжилт	862,213,400.00	-	862,213,400.00	-
Буцалтгүй тусламжийн санхүүжилт	-	-	-	-
Тохируулгын дүн		208,732,386.65		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	6,553,851,658.21		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	6,321,720,321.27		
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
Байгууллагын тоо	1			
Ажиллагсдын тоо	11			
Удирдах ажилтан	1			
Гүйцэтгэх ажилтан	10			

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2018 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код:	САГ-2020/180/СТА-ТХН
Шалгагдсан байгууллагын нэр:		Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-1			Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтан	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
А	3	4.0	5	8	9
1	Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд 11 дүгээр сарын цалингийн зардлыг 436.4 мянган төгрөгөөр илүү, 9 дүгээр сард 4,542.8 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17.1.1 "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх", 17.1.2 "шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх" гэснийг хэрэгжүүлээгүй байна.	4,106.4	Зөвлөмж	Төслийн зохицуулагч Санхүүгийн ажилтан	А.Хүрэлбат Н.Отгонжаргал
Нийт дүн		4,106.4			